

1. АЯЛАГЧИД АЯЛЛЫН КОМПАНИАС ГАРГАСАН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГАТАЙ САЙТАР УНШИЖ, МЭДЭЭЛЛЭЭ АВСАН БАЙХ.
2. АЯЛАГЧИД АЯЛАЛД ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТУУДЫГ АЯЛАЛЫН КОМПАНИД ҮНЭН ЗӨВӨӨР БҮРЭН ГҮЙЦЭД БҮРДҮҮЛЖ ӨГСӨН БАЙХ.
3. АЯЛАГЧДЫН ГАДААД ПАСПОРТ СУНГАЛТГҮЙ БАЙХ БӨГӨӨД ХУГАЦАА НЬ АЯЛАЛ ДУУСАХ ӨДРӨӨС ХОЙШ БАГАДАА 6 САРААС ДЭЭШ ХҮЧИНТЭЙ БАЙХ.
4. АЯЛАГЧ НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯМАР НЭГЭН АСУУДАЛТАЙ МӨН ЭМЧИЙН ХЯНАЛТАНД БАЙДАГ ТОХИОЛДОЛД ӨӨРИЙН БИЕИЙН БАЙДАЛЫГ ЗААВАЛ ЭМЧИД ҮЗҮҮЛЭН МАГАДЛУУЛСАН БАЙХ.
5. АЯЛАГЧ НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ШАЛТГААНААР СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ БЭЛДМЭЛ ХЭРЭГЛЭДЭГ БОЛ ЭМЧИЙН ЗААВАРТАЙ ТАМГА, ГАРИЙН ҮСЭГ БҮХИЙ БИЧИГ АВАН БАТАЛГААТ ОРЧУУЛГЫН ТӨВӨӨР АНГЛИ ХЭЛ ДЭЭР ХӨРВҮҮЛЭН БИЕДЭЭ АВЧ ЯВАХ.
6. АЯЛАГЧ ТА ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДАГУУ ХИЛИЙН ХОРИГТОЙ ЭСЭХЭЭ УРЬДЧИЛАН ШАЛГАСАН БАЙХ. (ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙГООР АЯЛАЛД ХАМРАГДАЖ ЧАДАХГҮЙ ТОХИОЛДОЛД ТАНЫ ТӨЛБӨР БУЦААН ОЛГОГДОХГҮЙ.)
7. АЯЛАГЧ НЬ ӨӨРИЙН ХҮҮХДЭЭС БУСАД НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХЭД БАТЛАН ДААН АВЧ ЯВАХ ТОХИОЛДОЛД ЗААВАЛ ИТГЭМЖЛЭЛ ХИЙЛГЭН АВЧ ЯВНА.
8. АЯЛАГЧ БҮР АЯЛАЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨ ДООРХ ЗӨВЛӨГӨӨГ НЭГ БҮРЧЛЭН ШАЛГАЖ ҮЗЭХ:



1. АЯЛАГЧИД ОНГОЦ НИСЭХ ЦАГААС 3 ЦАГИЙН ӨМНӨ ОНГОЦНЫ БУУДАЛ ДЭЭР ЦУГЛАРАН БЭЛТГЭЛТЭЙ БАЙХ.

2. АЯЛАГЧИД ХӨТӨЧ, АЯЛЛЫН МЕНЕЖРИЙН ӨГСӨН ЗААВАР ЗӨВЛӨГӨӨГ АНХААРАЛТАЙ СОНСОН ХЯНАН, МӨРДӨЖ ХУВИЙН БЭЛТГЭЛЭЭ ХАНГАХ.

3. АЯЛАЛД АВЧ ЯВАХ АЧААНЫ ХЭМЖЭЭ:

● ГАР ТЭЭШ 5-7КГ

● ТОМ ТЭЭШ 20КГ- ААС ИЛҮҮГҮЙ БАЙНА.

(ЗААСАН ХЭМЖЭЭНЭЭС ХЭТЭРСЭН ТОХИОЛДОЛД ИЛҮҮ АЧААНЫ ТӨЛБӨРИЙГ ГАЗАР ДЭЭР НЬ АЯЛАГЧ ӨӨРӨӨСӨӨ ТӨЛӨХ ШААРДЛАГАТАЙ БОЛОХЫГ АНХААРНА УУ! 1КГ-10\$)

4. АЯЛАГЧИД ХУВИЙН ХЭРЭГЛЭЭ БУЮУ БЭЛЭН МӨНГӨ, ҮНЭТ ЭДЛЭЛ, БИЧИГ БАРИМТАА ГАР ТЭЭШЭНДЭЭ БОЛОН БИЕДЭЭ АВЧ ЯВАХ.

5. АЯЛАГЧ ТА ӨӨРӨӨСӨӨ ГАДНА ТАНИЛ БОЛОН ТАНИХГҮЙ ХҮМҮҮСИЙН АЧАА БАРАА ЗӨӨВӨРЛӨЖ ЯВАХ НЬ ТАНЫГ ЭРСДЭЛД ОРУУЛЖ БОЛЗОШГУЙГ АНХААРНА УУ !

6. АЯЛАГЧ ТА ТОМ ТЭЭШЭНДЭЭ POWER BANK БОЛОН БАТЕРЕЙ ЦЭНЭГЛЭГЧ, ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР , ЯМАР НЭГЭН ЦАХИЛГААН БАРАА АВЧ ОРОХЫГ ХОРИГЛОНО /20,000 АМН/. ЭДГЭЭР ЗҮЙЛСИЙГ ЗӨВХӨН ГАР ТЭЭШЭНДЭЭ АВЧ ОРНО.

7. АЯЛАГЧ ТА ХИЛ ГААЛИАР НЭВТРЭХ ҮЕДЭЭ БИЕДЭЭ АВЧ ЯВАА БЭЛЭН МӨНГӨНИЙ ТООГ ҮНЭН ЗӨВӨӨР МЭДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ. БУРУУ МЭДҮҮЛНЭЭС ҮҮСЭХ ҮР ДАГАВРЫГ АЯЛАГЧ ӨӨРӨӨ ХАРИУЦАХ БОЛНО.

8. АЯЛАГЧ ГАР ТЭЭШЭНДЭЭ ШИНГЭН ЭД ЗҮЙЛС АВЧ ОРОХЫГ ХОРИГЛОХ БА ГАР ТЭЭШЭНДЭЭ ЗӨВХӨН 100МГ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХЭМЖЭЭТЭЙ ШИНГЭН БОЛОН ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН АВЧ ОРОХЫГ ЗӨВШӨӨРНӨ. ТОМ ТЭЭШЭНДЭЭ ЯМАР НЭГЭН ШИНГЭН ЗҮЙЛСИЙН ТӨРӨЛД 2-ООС ДООШ БҮТЭЭГДЭХҮҮН ЗӨВШӨӨРНӨ.



1. НИСЛЭГИЙН ЦАГИЙГ ЧАНД МӨРДӨХ.
2. ОРОН НУТГИЙН ХӨТӨЧ КОМПАНИНЫ ТУГЫГ БАРИН НИСЭХ БУУДАЛ ДЭЭР ХҮЛЭЭЖ БАЙНА. ШУУД ЗОЧИД БУУДАЛ ХҮРГЭЖ ӨГНӨ.
3. АЯЛАГЧ НЬ ХӨТӨЛБӨРӨӨС ГАДУУРХ ЗАРДАЛ, НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР БУЮУ ГАДААД ДОТООДЫН ЯРИАНЫ ТӨЛБӨР, БУУДЛЫН ӨРӨӨНИЙ МИНИ-БАР, ГАР ЦАЙЛГАХ МӨНГӨ, ИЛҮҮ АЧАА ТЭЭШИЙН ЗАРДАЛ БОЛООД БУСДАД УЧРУУЛСАН ЭД ХОХИРОЛ, ӨРӨӨН ДОТОРХ ЭД ЗҮЙЛСИЙН ГЭМТЭЛ ЗЭРГИЙГ ӨӨРӨӨ БИЕ ДААН ХАРИУЦАХ.
2. АЯЛАГЧ БҮР ӨӨРИЙН ҮНЭ ЦЭНЭТЭЙ ГЭСЭН ГАДААД ПАСПОРТ ЭД ЗҮЙЛСЭЭ БИЕДЭЭ АВЧ ЯВАХ, ХАРИУЦАХ, ХАЯЖ ҮРЭГДҮҮЛЭХГҮЙ БАЙХ.
3. ӨНДӨР НАСТАЙ БОЛОН БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ АЯЛАГЧИД ТӨӨРЧ БУДИЛХААС СЭРГИЙЛЖ, ГРУПИЙН АЯЛАГЧ БОЛОН ХӨТӨЧӨӨС САЛЖ ЯВАХГҮЙГ АНХААРУУЛАХ БА ЭД ЗҮЙЛСЭЭ ГЭЭЖ МАРТАХ, ХУЛГАЙД АЛДАХААС СЭРЭМЖЛҮҮЛЭХ.
3. АЯЛАГЧ ТА ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ГАЗАР ХОГ ХАЯГДАЛ ХАЯЖ, ЭД ЗҮЙЛСИЙГ НЬ САНААТАЙ БОЛОН САНАМСАРГҮЙГЭЭР ХҮРЖ ГЭМТЭЛ УЧРУУЛАХГҮЙ БАЙХ.
4. АЯЛАГЧ ТА СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭРЭГЛЭСЭН ҮЕДЭЭ ЯМАР НЭГЭН АЗ СОРЬСОН ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ХИЙХЭЭС ТАТГАЛЗАХ. МӨН СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭРЭГЛЭСЭН ҮЕДЭЭ ДАЛАЙ БОЛОН УСАН БАСЕЙН ОРОХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.
5. АЯЛАГЧ ТА УСАН БАСЕЙНД ОРОХ ҮЕДЭЭ ӨӨРИЙН ТҮВШИНД ТААРСАН ХЭМЖЭЭНД СЭЛЭХ, ХАЛТИРЧ ГЭМТЭХЭЭС СЭРГИЙЛЭХ, БАГА НАСНЫ БОЛОН СЭЛЖ ЧАДАДГҮЙ ТОХИОЛДОЛД ХАРАА ХЯНАЛТТАЙГААР УСАН БАСЕЙНААР ҮЙЛЧЛҮҮЛЭХИЙГ ЗӨВЛӨЖ БАЙНА.
6. АЯЛАГЧ ТА АЯЛЛЫН ЧӨЛӨӨТ ӨДРӨӨРӨӨ ХЭН НЭГЭНД ХЭЛЭЛГҮЙ ГАНЦААРАА ХЭТ ХОЛ БОЛОН МЭДЭХГҮЙ ГАЗРААР ЗОРЧИХГҮЙ БАЙХЫГ ЗӨВЛӨЕ.
7. АЯЛАГЧ БҮР БУУДАЛД БАЙРЛАХ ҮЕДЭЭ БУУДЛЫН ИНТЕРНЭТ ҮНЭГҮЙ АШИГЛАЖ БОЛНО. (БУУДЛЫН ИНТЕРНЭТ ОРОХ НЭР БОЛОН НУУЦ ҮГИЙГ АЯЛЛЫН ХӨТӨЧӨӨР ДАМЖУУЛАН МЭДЭЖ БОЛНО.)
8. АЯЛАГЧ ТАНЬД ЯМАР ~~НЭГЭН МЭДЭЭЛЭЛ~~ АВАХ, МЭДЭХГҮЙ ЗҮЙЛЭЭ АСУУЛГАХ, АЯЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ, НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ЗЭРЭГ ТУСЛАМЖ ХЭРЭГ БОЛВОЛ АЯЛЛЫН ХӨТЧИД ХАНДАХ.

1.ГРУПП АЯЛЛААР ЯВЖ БАЙГАА ТОХИОЛДОЛД МӨН БИЧИГ БАРИМТЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛЭЭС ХАМААРЧ БУУДАЛД БҮРТГЭЛ ХИЙЛГЭХ ХУГАЦАА ООЧИРООС ХАМААРАН 20-60 МИНУТИЙН ХҮЛЭЭЛТ ҮҮСГЭДЭГ ТУЛ АЯЛАГЧ ТА ХАМТ НЭГ ӨРӨӨНД ОРОХ ХҮНТЭЙГЭЭ ГАДААД ПАСПОРТОО БЭЛЭН БАЙЛГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

2. АЯЛАГЧ ТА ХӨТӨЛБӨР ДЭЭРХ ЗААГДСАН ӨРӨӨНӨӨС ГАДНА НЭМЭЛТ БУЮУ ДАЛАЙ РУУ ХАРСАН ӨРӨӨ БОЛГОН СОЛИХ МӨН ӨРӨӨНИЙ ТООГ НЭМЭХ, НЭМЭЛТ ОР АВАХ ЗЭРЭГ ҮЙЛЧИЛГЭЭН ДЭЭР ӨӨРӨӨСӨӨ НЭМЭЛТ ЗАРДАЛ ГАРГАХЫГ АНХААРНА УУ!

3. БУУДЛЫН ӨРӨӨ БОЛГОНД АЯЛАГЧДАД ЗОРИУЛСАН НЭГ УДААГЫН САВАН, ШАМПУНЬ, АЛЧУУР, ВАНИЙН АЛЧУУР, ТАВЧИКА, ОО СОЙЗ, НОЙЛЫН ЦААС ЗЭРГЭЭР ХАНГАСАН БАЙДАГ ТУЛ ХЭРЭВ ДУТСАН ТОХИОЛДОЛД БУУДЛЫН АЖИЛЧИНД МЭДЭГДЭН АВАХ БОЛОМЖТОЙ. МӨН БУУДЛЫН НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЛҮҮД ИХЭНХИ ХҮМҮҮСД ТААРДАГГҮЙ ТУЛ ХАРШИЛ ӨГӨХ ТОХИОЛДОЛ ГАРДАГ ТУЛ ӨӨРСДӨД ТААРСАН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ АВЧ ЯВАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА. (БУУДЛЫН АЖИЛЧДААС ХАМААРАН ЗАРИМ ТОХИОЛДОЛД ӨРӨӨНҮҮДЭД БАЙХГҮЙ БАЙХ МАГАДЛАЛТАЙ. ТУХАЙН ҮЕД ХӨТӨЧДӨӨ ХЭЛЭН АВЧ БОЛНО)

4. АЯЛАГЧ ТА ӨРӨӨНИЙ ЦЭВЭРЛЭГЭЭ АВАХ БОЛ ҮҮДЭН ХЭСЭГТ БАЙРЛАХ (ROOM CLEANING) ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХОНХЫГ АСААЖ ИДЭВХЖҮҮЛЭН ӨРӨӨНИЙ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ЗӨВШӨӨРЛИЙГ ӨГСНӨӨР ӨРӨӨНД ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙГДЭХ БОЛНО.

5. АЯЛАГЧ ТА БУУДЛЫН ТАЛААРХ ХООЛНЫ ГАЗАР БОЛОН УСАН САН ЗЭРЭГ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЦАГИЙН ХУВААРИЙН МЭДЭЭЛЛИЙГ АЯЛЛЫН ХӨТӨЧӨӨР ДАМЖУУЛАН АВАХ БОЛОМЖТОЙ.



1. АЯЛАГЧ ТА МОНГОЛООС ХААШАА Ч АЯЛЛААР ЯВАХДАА ТУХАЙН ОРНЫ МӨНГӨН ДЭВСГЭРТ БАЙГАА ҮГҮЙГЭЭС ШАЛТГААЛАН АВЧ ЯВАХ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭРЭЭ ДОЛЛАР-ЫГ СОНГООРОЙ. ТУХАЙН УЛСЫНХАА ОНГОЦНЫ БУУДАЛ ДЭЭР МӨНГӨӨ СОЛИУЛЖ БОЛДОГ БӨГӨӨД ЭНЭ НЬ ИЛҮҮ АШИГТАЙ. (ХЭРЭВ ИХ ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ БОЛ ОЛОН УЛСЫН VISA КАРТААРАА ҮЙЛЧЛҮҮЛВЭЛ ЗОХИСТОЙ.)

2. 1\$-3410₮ ТЭЙ ТЭНЦЭХ БА ЭНЭ ҮНЭ НЬ ТОГТСОН ХАНШ БИШ БӨГӨӨД ТУХАЙН ЦАГ ҮЕИЙН ХАНШААСАА ШАЛТГААЛАН ХЭЛБЭЛЗЭНЭ.

3. ИХЭНХИ ОРНУУДАД ОЛОН УЛСЫН КАРТ УНШДАГ БА ТА ЗӨВХӨН ТӨГРӨГИЙН ЭСВЭЛ ДОЛЛАРЫН КАРТТАЙ БАЙХАД БОЛНО. ТУХАЙН ОРНЫ БАНКНААСАА ХАМААРААД ШИМТГЭЛ НЬ ӨӨР, ӨӨР БАЙНА. PAGE * MERGEFOR MAT 2

4. УЛС ОРОН БОЛГОНД БРЭНДИЙН БОЛОН ОЛОН УЛСЫН ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ТОХИОЛДОЛД 10% -ИЙН (TAX FREE) БАРИМТААР ОЛГОГДДОГ ТУЛ БУЦАХ ҮЕДЭЭ ОНГОЦНЫ БУУДАЛ ДЭЭРЭЭС ХҮЛЭЭН АВАХ БОЛОМЖТОЙ. ТИЙМЭЭС ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН БАРИМТАА ХАЯХГҮЙ БАЙХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

5. ИХЭНХИ УЛС ОРНЫ ХУДАЛДААНЫ ГАЗРУУДАД ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД ЗАРЛАГДСАН БАЙДАГ БА АЯЛАГЧ ТА ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ ҮЕДЭЭ ҮНЭЭ БУУРУУЛАХ ТАЛААС ЯРИЛЦАН ТОХИРОЛЦОЖ БОЛНО.(БРЭНДИЙН МАЛЛУУДАД ҮНЭ БУУРУУЛАХ ТОХИРОЛЦОО ҮЙЛЧЛЭХГҮЙ БОЛОХЫГ АНХААРНА УУ.)

6. АЯЛАГЧ ТА ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ТОХИОЛДОЛД БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ДЭЛГҮҮРТЭЭ МАРТАХ, КАРТАА ХАЯЖ ГЭЭХ ЗЭРЭГ ЭРСДЭЛД ОРОХООС СЭРГИЙЛЭЭРЭЙ.



1. АЯЛАГЧ ТА МОНГОЛООС ХААШАА Ч АЯЛЛААР ЯВАХДАА ТУХАЙН ОРНЫ МӨНГӨН ДЭВСГЭРТ БАЙГАА ҮГҮЙГЭЭС ШАЛТГААЛАН АВЧ ЯВАХ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭРЭЭ ДОЛЛАР-ЫГ СОНГООРОЙ. ТУХАЙН УЛСЫНХАА ОНГОЦНЫ БУУДАЛ ДЭЭР МӨНГӨӨ СОЛИУЛЖ БОЛДОГ БӨГӨӨД ЭНЭ НЬ ИЛҮҮ АШИГТАЙ. (ХЭРЭВ ИХ ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ БОЛ ОЛОН УЛСЫН VISA КАРТААРАА ҮЙЛЧЛҮҮЛВЭЛ ЗОХИСТОЙ.)

2. 1\$-3410₮ ТЭЙ ТЭНЦЭХ БА ЭНЭ ҮНЭ НЬ ТОГТСОН ХАНШ БИШ БӨГӨӨД ТУХАЙН ЦАГ ҮЕИЙН ХАНШААСАА ШАЛТГААЛАН ХЭЛБЭЛЗЭНЭ.

3. ИХЭНХИ ОРНУУДАД ОЛОН УЛСЫН КАРТ УНШДАГ БА ТА ЗӨВХӨН ТӨГРӨГИЙН ЭСВЭЛ ДОЛЛАРЫН КАРТТАЙ БАЙХАД БОЛНО. ТУХАЙН ОРНЫ БАНКНААСАА ХАМААРААД ШИМТГЭЛ НЬ ӨӨР, ӨӨР БАЙНА. PAGE * MERGEFOR MAT 2

4. УЛС ОРОН БОЛГОНД БРЭНДИЙН БОЛОН ОЛОН УЛСЫН ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ТОХИОЛДОЛД 10% -ИЙН (TAX FREE) БАРИМТААР ОЛГОГДДОГ ТУЛ БУЦАХ ҮЕДЭЭ ОНГОЦНЫ БУУДАЛ ДЭЭРЭЭС ХҮЛЭЭН АВАХ БОЛОМЖТОЙ. ТИЙМЭЭС ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН БАРИМТАА ХАЯХГҮЙ БАЙХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

5. ИХЭНХИ УЛС ОРНЫ ХУДАЛДААНЫ ГАЗРУУДАД ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНД ЗАРЛАГДСАН БАЙДАГ БА АЯЛАГЧ ТА ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ ҮЕДЭЭ ҮНЭЭ БУУРУУЛАХ ТАЛААС ЯРИЛЦАН ТОХИРОЛЦОЖ БОЛНО.(БРЭНДИЙН МАЛЛУУДАД ҮНЭ БУУРУУЛАХ ТОХИРОЛЦОО ҮЙЛЧЛЭХГҮЙ БОЛОХЫГ АНХААРНА УУ.)

6. АЯЛАГЧ ТА ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ТОХИОЛДОЛД БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ДЭЛГҮҮРТЭЭ МАРТАХ, КАРТАА ХАЯЖ ГЭЭХ ЗЭРЭГ ЭРСДЭЛД ОРОХООС СЭРГИЙЛЭЭРЭЙ.



1. АЯЛАЛ ГАРГАЖ БУЙ ОРНУУД МААНЬ ИХЭВЧЛЭН ХАЛУУН УУР АМЬСГАЛТАЙ, ДАЛАЙН ОРНУУД БАЙДАГ ТУЛ ЕРӨНХИЙДӨӨ НИМГЭН ЗУНЫ ХУВЦАС, УГЛААШ АВЧ ЯВАХАД ТОХИРОМЖТОЙ. АЯЛАЛД АЛХАЖ, ГҮЙЖ ХАРАЙХАД БИЕД ХӨНГӨН, ТАВ ТУХТАЙ ХӨЛӨРГӨДӨГГҮЙ МАТЕРИАЛТАЙ БАЙВАЛ БҮР САЙН. (БИЕИЙН ТАМИРИЙН НИМГЭН ӨМД, ЦАМЦ, ПОДВОЛК, ПҮҮЗ Г.М)

2. ЗАРИМ ОРОНД МӨР БОЛОН ӨВДӨГ ГАРГАСАН ЗАДГАЙ ХУВЦЛАЛТЫГ ХОРИГЛОСОН БАЙДАГ (ЖИШЭЭ НЬ: АРАБ) БА ХОРИГЛООГҮЙ ОРОН БАЙСАН Ч ЗАРИМ ҮЗВЭРҮҮДЭД ЗАДГАЙ ХУВЦАСЛАЖ ОРОХЫГ ХОРИГЛОСОН БАЙДАГ (ЖИШЭЭ НЬ: ВЬЕТНАМ ДАХЬ ХААНЫ ОРДНЫ МУЗЕЙ, ХО ШИ МИНИ ТАЛБАЙ, ТАЙЛАНД ДАХЬ АЛТАН ОРДОН, ХАЙНАН ДАХЬ ЭМЭГТЭЙ БУДДАН АРАЛ Г.М) ТУЛ МЭДЭЭГҮЙ ОЧСОН ТОХИОЛДОЛД ОРУУЛАХГҮЙ БАЙХААС ГАДНА ТОРГОХ АЮУЛТАЙ ТУЛ АЯЛЛЫН ХӨТӨЧӨӨСӨӨ САЙТАР МЭДЭЭЛЭЛ АВСАН БАЙХ.

3. АЯЛЛЫН ҮЕЭР БИД АВТОБУСААР ЗОРЧДОГ ТУЛ АВТОБУСАН ДОТОР БАЙНГА ХҮЙТЭН КОНДИШН АЖИЛЛАЖ БАЙДАГ. ТИЙМЭЭС ЭМЗЭГ ХҮМҮҮС ДУЛААН ЦАМЦ ӨМД ДАВХАР АВЧ ЯВБАЛ ТОХИРОМЖТОЙ. МӨН ЦАГ АГААРЫН ГЭНЭТИЙН БАЙДАЛД БЭЛТГЭЛТЭЙ БАЙХ НЬ ЯМАР НЭГЭН ӨВЧЛӨЛӨӨС СЭРГИЙЛНЭ.

4. МЭДЭЭЖ АЯЛАЛЫН НЭГЭН ЧУХАЛ ЗҮЙЛ БОЛ ЗУРАГ АВАЛТ ЮМ. ТИЙМЭЭС АЯЛАГЧ ТА ХӨТӨЛБӨРТЭЙГӨӨ САЙТАР ТАНИЛЦАН ЗУРАГ АВАЛТАНДАА ТОХИРУУЛАН ГОЁЛЫН ХУВЦАСНУУДАА (ДААШИНЗ, ӨСГИЙТ, ЭЭМЭГ ЗҮҮЛТ, ЮБКА, ЦАМЦ, ПОДВОЛК Г.М) ТААРУУЛАН БЭЛДЭЭРЭЙ.

